



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР**



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Улаанбаатар хот
2024 он**

ГАРЧИГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	1-3
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	3-6
ГУРАВ. АЛСЫН ХАРАА.....	6
ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО.....	6
ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ.....	6-9
ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО.....	9
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ.....	9-10
НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ.....	10-22

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Зорилго. Шүүх шинжилгээний байгууллагын хөгжлийн хандлага, 2024-2028 он хүртэлх хугацаанд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргахад энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

Зорилт. Дараах зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгасан болно.

- Шүүх шинжилгээний байгууллагын өнөөгийн тулгамдсан асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлах;
- Байгууллагын өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул тал, боломж, эрсдэлийг эрэмбэлэх;
- Байгууллагын стратегийн зорилт, уялдаа холбоо, нийтлэг асуудлыг судлах, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлах;
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдааг харуулах.

Стратеги төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим. Төлөвлөгөөг “Ухаалаг” (SMART) буюу зорилго тодорхой байх (S-Specific), хэмжиж болохуйц (M-Measurable), зорилгодоо хүрч болохуйц байх (A-Attainable), бодитой байх (R-Relevant), цаг хугацаатай байх (T-Time based) зарчмуудыг агуулсан байхаар боловсрууллаа.

Төлөвлөгөөний хамрах хүрээ. Шүүх шинжилгээний ерөнхий газар түүний харьяа газар, төв, хэлтэс, хэсэг, тасгийн үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн 2024-2028 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлов.


Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн. Энэхүү төлөвлөгөө нь бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд Шүүх шинжилгээний ерөнхий газар түүний харьяа газар, төв, хэлтэс, хэсэг, тасгийн үйл ажиллагааг уялдуулан цогц байдлаар төлөвлөсөн баримт бичиг юм.

Уг төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр үйл ажиллагаандаа цахим шилжилтийг бүрэн хийж, олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлж, магадлан итгэмжлэгдсэн лабораторид үзлэг, шинжилгээ хийж, шинэ төрлийн шинжилгээ хийхэд шаардлагатай дэвшилтэд техник, технологи, программ хангамж, арга, аргачлалыг нэвтрүүлж, алба хаагчдын ажлын ачаалал тэнцвэржиж, улмаар шинжээчийн дүгнэлтийн чанар, үр дүн дээшилж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан хараат бус байдал хангагдана.

Мөн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, шинжээч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх болон давтан сургалтад хамруулж, Бүсийн шүүх шинжилгээний төвүүдийн үйл ажиллагааг жигдэрч, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж иргэдэд төрийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөл бүрдэж, төрд итгэх үнэмшил, сэтгэл ханамжийн түвшин нэмэгдэнэ.

Шүүх шинжилгээний байгууллага нь 5 аймагт Бүсийн шүүх шинжилгээний төв, 16 аймагт Шүүх шинжилгээний хэлтэс, 8 суманд шүүх шинжилгээний хэсэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь энэ байгууллагын цар хүрээ өргөн, эрхлэх асуудал нь Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан байгаагийн илэрхийлэл юм.

Зураг. Тус байгууллагын харьяа Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс, хэсгүүдийн байршлыг харуулав.



Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, туршлагыг судлах, хүртээмжтэй өсөлт, тасралтгүй хөгжилд чиглэсэн зорилтот түвшин, хүрэх үр дүнг тооцлоо. Бодлогын зорилт, үйл ажиллагааг тодорхойлохдоо ач холбогдлоор нь эрэмбэлэн, хэрэгжүүлэхэд гарч болох саад бэрхшээлүүдийг урьдчилан тооцож, хариу авах арга хэмжээг судалж, төлөвлөгөөнд тусгах зэрэг арга зүйг баримталсан болно.

Эрхлэх асуудлын хүрээний цар хүрээ, газар нутгийн хэмжээ, нутаг дэвсгэрийн онцлог, тархалт, нягтрал, байгаль, цаг уурын байдал, нийгэм, эдийн засаг, улс төр, олон улсын чиг хандлага зэргээс хамаарч салбарын өмнө тулгарсан асуудлыг шийдвэрлэх арга зам нь төлөвлөлт юм.

Стратеги төлөвлөгөөг оновчтой, бодитой боловсруулахын тулд байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойлж, ач холбогдлын зэрэглэлээр нь эрэмбэлэв.

1.1. БАЙГУУЛЛАГЫН ӨМНӨ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Тулгамдсан асуудлуудын эрэмбэ:		
Нэн их	Их	Дунд
ДОЛОО. ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР		
Нэгдсэн менежментийн тогтолцоо бүрэн хэрэгжиж төлөвшөөгүй.	Шинжилгээ хийх зориулалт бүхий орчин, нөхцөл хангалтгүй, үзлэг, шинжилгээний техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тогтмолжуулаагүй.	Хүний нөөц хангалтгүй буюу шинжээчдийн орон тоо бага, нэг шинжээчид ногдох шинжилгээ, ажлын ачаалал их.

1.2. СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна”, мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.3-т “Яамны харьяа агентлаг нь байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан салбарын сайдаар, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг аймаг, нийслэлийн Засаг даргаар тус тус батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна” гэж заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тусгагдсан стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг 2024-2028 онд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/150 дугаар тушаалын зургадугаар хавсралтаар баталсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, ажил, арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч орон нутагт лабораторийн зориулалттай байртай болох зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв батлагдаагүйн улмаас шинэ төрлийн шинжилгээ хийх лаборатори байгуулж иргэдэд үзлэг, шинжилгээг жигд хүртээмжтэй хүргэх боломжгүй байна.

Иймд Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ төрлийн шинжилгээний арга, аргачлал нэвтрүүлэх, үйл ажиллагаанд чанарын менежментийг тогтолцоог нэвтрүүлж, магадлан итгэмжлэгдсэн лабораторид үзлэг шинжилгээ хийх, хүний нөөцийг чадавхжуулах, орчин үеийн техник-технологийн дэвшлийг нэвтрүүлэн шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилгоор “Шүүх шинжилгээний байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”-г боловсрууллаа.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын шинжилгээгээр Шүүх шинжилгээний байгууллагын хэмжээнд нийт 22 хууль тогтоомж мөрдөгдөж байгаагаас үндсэн чиг үүргийн хүрээнд шууд хамаарах 1 хуулийн хүрээнд байгууллагын чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Байгууллагын чиг үүрэг нь үзлэг, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, бусад гэсэн 2 ерөнхий чиг үүрэгт хуваагдан, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүрэг болон дараах байдлаар нарийвчлагдан тусгагдсан болно.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо:		Нийт 22 хууль
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо:	1
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо:	21
Ерөнхий чиг үүрэг-1: Эрүү, иргэн, захиргаа, арбитрын хэрэг маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн		

баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, шинжилгээ, үнэлгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр Инженер-техникийн чиглэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах.	Дүр зургийн шинжилгээ хийх	Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч
	Дүрс бичлэгийн шинжилгээ хийх	
	Дуу авианы шинжилгээ хийх	
	Авто техникийн шинжилгээ хийх	
	Компьютер техникийн шинжилгээ хийх	
	Инженер техникийн шинжилгээ хийх	
ҮЧҮ-2: Мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр Байгалийн ухааны чиглэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах.	Хүрээлэн буй орчны шинжилгээ хийх	Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч
	Биологийн шинжилгээ хийх	
	ДНХ-ийн шинжилгээ хийх	
	Химийн шинжилгээ хийх	
	Физикийн шинжилгээ хийх	
ҮЧҮ-3: Мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр Шүүх анагаах ухааны чиглэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах.	Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох үзлэг, шинжилгээ хийх	Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч
	Шүүх сэтгэцийн шинжилгээ хийх	
	Бэлгийн маргаантай гэмт хэргийн хохирогчид үзлэг хийх	
	Цогцост задлан шинжилгээ хийх	
	Эд эсийн шинжилгээ хийх	
	Бактериологийн шинжилгээ хийх	
	Нас, хүйс тогтоох	
	Хавтаст хэргийн материалаар шинжилгээ хийх	
	Эксгумаци (оршуулсан шарилд) шинжилгээ хийх	

<p>ҮЧҮ-4: Мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр Криминалистикийн чиглэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах.</p>	Бичиг баримтын шинжилгээ хийх	<p>Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч</p>
	Галт зэвсэг, тэсрэх төхөөрөмжийн шинжилгээ хийх	
	Гарын мөрийн шинжилгээ хийх	
	Мөр судлалын шинжилгээ хийх	
<p>ҮЧҮ-5: Мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр Эдийн засгийн чиглэлээр шинжилгээ хийж дүгнэлт гаргах.</p>	Эдийн засгийн шинжилгээ хийх	<p>Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч</p>
	Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийх	
<p>ҮЧҮ-5: Эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн газарт мэргэжилтнээр оролцох.</p>	Хэргийн газраас нотлох баримтыг илрүүлэн бэхжүүлж авах	<p>Мөрдөгч, Прокурор, Шүүгч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, Бүртгэл мэдээлэл, технологийн хэлтэс, шинжээч</p>
	Хэргийн газрын ул мөр, эд мөрийн баримтад үзлэг хийх	
<p>ҮЧҮ-6: Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.</p>	Гарын мөрийн сан.	<p>ТЕГ, ЦЕГ, Шүүгч, шинжээч болон бусад</p>
	Галт зэвсгийн хонгио, хошууны сан.	
	Генетик мэдээллийн сан.	
	Үнэлгээний мэдээллийн сан.	
<p>ҮЧҮ-7: Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн сан бүрдүүлэх.</p>	Экологийн шинжилгээний сан.	<p>ТЕГ, ЦЕГ, Шүүгч, шинжээч болон бусад</p>
	Бичиг баримтын сан.	
	Үнэт цаас, мөнгөн дэвсгэртийн сан.	
	Тамга тэмдэг, түүний дардасны сан.	
	Гутлын мөрийн сан.	
	Тээврийн хэрэгслийн мөрийн сан.	
	Нэр, хаяг тодорхойгүй цогцосны мэдээллийн сан.	
	Шүүх дүрс оношилгооны мэдээллийн сан.	
Бусад		

Ерөнхий чиг үүрэг-2: Бусад чиг үүрэг		
ҮЧҮ-1:Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож хуулийн хэрэгжилтийг хангах.	Шүүх шинжилгээний сургалтыг зохион байгуулж, шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох.	-
ҮЧҮ-2:Бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийлэлд өртөж болзошгүй хохирогч, түүний бага насны хүүхдийг тус газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д түр буюу 24 цагийн хугацаанд байрлуулах.	Эмнэлгийн туслалцаа үзүүлэх, хууль, эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх.	ЦЕГ, НҮБ-ын хүн амын сан

ГУРАВ. АЛСЫН ХАРАА-VISION

Шүүх шинжилгээний үйл ажиллагааг Олон Улсын жишигт хүргэх.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО-MISSION

Шүүх шинжилгээ нь нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шинжлэх ухааны баталгаа болно.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

SWOT шинжилгээний арга зүй. Байгууллагын хэмжээнд тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT шинжилгээг холбогдох судалгаа баримтад үндэслэн дараах ерөнхий арга зүйн хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Дотоод хүчин зүйл: Хөрөнгө, материал, ажиллах хүч, технологи, инноваци, чадавх, менежмент зэрэг байгууллагын дотоод боломжийн эерэг, сөрөг талыг нягтлан үзэж, одоогийн түвшин, цаашдын хөгжлийн хандлагыг тогтоох.

Гадаад хүчин зүйл: Байгаль орчин, институц (төрийн бодлого, төсөв, олон улсын болон, дотоодын хууль, журам, тогтсон заншил), дотоод, гадаад зах зээлийн төлөв байдал, өрсөлдөгч зэрэг байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн таатай болон таагүй нөлөөг салбарын хэмжээнд тодорхойлох.

SWOT шинжилгээ	
Дотоод орчин	
Давуу тал:	Сул тал:
1. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Шүүх шинжилгээний тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдаж, Монгол Улсын Засгийн	1.Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор батлагдсан дүрэм, журам, зааврын хэрэгжилт хангалтгүй;

<p>газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг-Шүүх шинжилгээний ерөнхий газар болж бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа өргөжиж “цахим технологи, инженер-техник, хөрөнгийн үнэлгээ болон байгаль орчны хохирлын үнэлгээ, гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох” зэрэг шинэ төрлийн шинжилгээнүүдийг хийж эхэлсэн;</p> <p>2.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 182 дугаар тогтоолоор “Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд” аймагт бүсийн Шүүх шинжилгээний төвүүдийг байгуулсан;</p> <p>3.ДНХ, Хими, Дижитал, Бичиг баримтын шинжилгээний лабораториудын 19 шинжээчийг БНСУ-ын Үндэсний шүүх шинжилгээний байгууллагад 45 хоногийн хугацаатай сургалтад хамруулж, БНСУ-ын шинжээч, мэргэжилтнүүдийг урьж, сургалт зохион байгуулсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн, сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологи бүхий лабораториудыг хүлээн авсан;</p> <p>4.Шинжилгээний төрөл, зүйл тодорхой хэмжээнд нэмэгдэж, шинжээч томилох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор шинжээчид цахимаар хуваарилж эхэлсэн;</p> <p>5.Адил зэрэглэлд хамаарах алба хаагчдын цалингийн зөрүүтэй байдал арилсан;</p> <p>6.Мэргэжлийн хүний нөөцийг гадаад, дотоодын их дээд сургуулиудад бэлтгэдэг;</p> <p>7.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс шинжээч нар хараат бус байж гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа бие даан явуулах бодит бололцоог бий болгож чадсан;</p>	<p>2.Бүсийн шүүх шинжилгээний төв, хэлтсүүд ажлын байр болон шинжилгээний лаборатори, техник, тоног төхөөрөмжөөр жигд хангагдаагүй, хүний нөөц дутмаг;</p> <p>3.Төсвийн хувьд хязгаарлагдмал тул хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ нийслэл, аймаг, орон нутагт жигд хүртээмжтэй бөгөөд түргэн шуурхай хүргэхэд хүндрэлтэй;</p> <p>4.Албан хаагчдын ажлын ачаалал жигд биш, зарим ажил, арга хэмжээг хэт шахуу хугацаанд хийж гүйцэтгэдэг;</p> <p>5.Барилга, инженерийн байгууламж, цахим технологи, хэргийн газрыг сэргээн дүрслэх, авто техник, хүрээлэн буй орчин, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис, шүүх сэтгэц, хөрөнгийн үнэлгээ гэх мэт шинэ төрлийн шинжилгээний техник, тоног төхөөрөмж, программ хангамж, стандартын шаардлага хангасан лаборатори, туршилт, судалгаа, шинжилгээ хийх зориулалтын ажлын орчин нөхцөл, мэргэшсэн хүний нөөц дутмаг;</p> <p>6.Тус газрын шинжилгээний зарим лабораториудад ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмж хуучирсан, ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон;</p> <p>7.Тус газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын барилга 1970 онд баригдсан бөгөөд стандартын шаардлага хангахгүй хуучирсан тул цаашид ашиглах боломжгүй талаар мэргэжлийн хяналтын албаны дүгнэлт гарсан;</p> <p>8.Шүүх анагаах ухааны шинжилгээний ачаалал хэт өндөр, шинжилгээ хийх өрөө тасалгааны нөхцөл /агааржуулалт/, шинжилгээний багаж хэрэгсэл хангалтгүй, цогцос хадгалах хөргөгч хүрэлцдэггүй;</p>
---	--

<p>8.Улаанбаатар хотын төвд үйл ажиллагаагаа явуулах албаны байртай;</p> <p>9.Шинжилгээний нэгдсэн болон төрөлжсөн сантай;</p> <p>10.Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэдэг, дотоод хяналт шалгалт сайн;</p>	
Гадаад орчин	
Боломж:	Эрсдэл:
<p>1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)”-ийн бэлтгэл ажлын хүрээнд архитектур төлөвлөлтийн даалгаврыг шинэчлэн батлуулж, далан ухаж, төсөл хэрэгжүүлэх барилгын талбайг бэлдсэн бөгөөд Хот байгуулалт, хотын стандартын газрын Мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хурлаар Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын барилгын загвар зураг дэмжигдсэн.</p> <p>Дээрх төслийг амжилттай хэрэгжүүлснээр Шүүх анагаах ухааны шинжилгээний барилгыг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн шинээр барьж, сүүлийн үеийн дэвшилтэд техник, технологи бүхий тоног төхөөрөмжөөр хангагдаж, шинжээч эмч нарыг сургаж, мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлж, шинжилгээний чанар, үр дүнд ахиц гарна.</p> <p>2.Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, төрөл бүрийн төсөл, хөтөлбөрт хамрагдах;</p> <p>3.Шинэ төрлийн шинжилгээ хийж байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх;</p> <p>4.Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтсүүдийн нэг загварын лабораторийн барилгыг барих, шинэ төрлийн</p>	<p>1.Одоогийн ажиллаж байгаа хүний нөөц хүрэлцээгүй, орон тооны нөхөн хангалт дутмаг байгаагаас шалтгаалан шинжээчид ногдох шинжилгээний тоо, ажлын ачаалал эрс нэмэгдсэнээс шинжилгээний хугацаа алдах, мэргэшсэн туршлагатай алба хаагчид бусад байгууллагад шилжих;</p> <p>2.Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, алба хаагчдыг сургаж, мэргэшүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилтийг шийдвэрлээгүйн улмаас үндсэн үйл ажиллагааг явуулахад хүндрэл үүсэх;</p> <p>3.Шүүх анагаах ухааны шинжилгээний газар болон орон нутгийн зарим нэгжүүд лабораторийн барилга байгууламжгүйн улмаас хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй, иргэдэд төрийн үйлчилгээг жигд, хүртээмжтэй, шуурхай хүргэхэд хүндрэл үүсэх зэрэг эрсдэлүүд тулгарч байна.</p>

<p>шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг худалдан авах, алба хаагчдыг сургаж бэлтгэх, байгууллагын төсвийг нэмэгдүүлэх, бүтэц, орон тоог боловсронгуй болгож орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтой.</p>	
--	--

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

6.1. Стратегийн зорилго

Байгууллагын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцсэн шүүх анагаах ухааны шинжилгээний болон цогцос хадгалах байр, бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтсүүдэд нэг загварын лабораторийн барилгуудыг барих, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг худалдан авах, алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах, төсөв, орон тоог үе шаттайгаар нэмэгдүүлэхэд оршино.

6.2. Стратегийн зорилт

Байгууллага стратегийн зорилгодоо хүрэхийн тулд дараах үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах;
2. Шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт арга барил, олон улсын стандартыг нэвтрүүлж, шинжилгээний лабораториудыг магадлан итгэмжлүүлж олон улсын жишигт хүргэх;
3. Үйл ажиллагааны стандартыг чанд мөрдөж, хууль эрх зүйн актын хүрээнд иргэд, хууль хяналтын байгууллагуудад түргэн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэх;
4. Шүүх шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшин болон эрдмийн цол зэргийг дээшлүүлэх;
5. Байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, гадаад орны болон олон улсын байгууллагуудтай харилцах бүх талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ


Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангахад Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах талуудын оролцоо, дэмжлэг, туслалцаа, уялдаа холбоо, харилцан хамтын ажиллагаа чухал билээ. Сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратегийн чиглэл, салбарын бүтцийн уялдаа холбоо, оролцогч талуудын хамаарал зэргийг цогц бүдүүвч, зураглалаар харуулав.

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”

“ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР”

ХУУЛЬ ЗҮЙ,
 ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН 2024-2028 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

(Шүүх шинжилгээний ерөнхий газар)

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин (2024-2028)	Санхүүгийн эх үүсвэр
ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ДЭМЖИЖ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЖ, МЭРГЭШСЭН ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛНЭ. ("АЛСЫН ХАРАА-2050" БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ 7.4)					
НЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.					
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ	1.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг судалж, холбогдох хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар байгууллагын эрх зүйн орчин боловсронгуй болж, алба хаагчийн нийгмийн баталгаа, иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэнэ.	Нэмэлт, өөрчлөлт оруулсан эрх зүйн актын тоо	1	1	Улсын төсөв, 6,850.0 сая төгрөг
МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ	1.2."ISO 9001:2015" чанарын менежментийн тогтолцооны шаардлага стандартыг байгууллагын үйл ажиллагаанд төлөвшүүлэх ажлын хүрээнд магадлан болон баталгаажуулалтын аудитад амжилттай хамрагдаж, 2028 онд гэрчилгээг дахин авсан байна.	Гэрчилгээний тоо	0	1	Улсын төсөв 2,240.0 сая төгрөг
	1.3."MNS ISO/IEC 17025:2018 сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага стандарт"-ыг нэвтрүүлж, шинжилгээний 13 лабораторийн үйл ажиллагааг Үндэсний итгэмжлэлийн төвөөр баталгаажуулж, гэрчилгээ авна.	Итгэмжлэгдсэн лабораторийн тоо	0	13	
	1.4.Байгууллагын үйл ажиллагаанд "ISO 27001: 2022 Мэдээллийн аюулгүй байдлын менежмент", "ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдлын менежмент"-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд	Зөвлөх үйлчилгээ авсан тоо	0	2	Улсын төсөв 250.0 сая төгрөг

	шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж, зөвлөх үйлчилгээ авна.				
ХОЁР АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА, АЖИЛЛАХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛЖ, МЭРГЭШСЭН ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛНЭ.					
АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГАА, АЖИЛЛАХ ОРЧИН, НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ	<p>2.1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр "Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)"-ийг хэрэгжүүлж, Шүүх анагаах ухааны шинжилгээний олон улсын жишигт нийцсэн лабораторийн зориулалттай барилгатай болж, сүүлийн үеийн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжийг хүлээн авч, суурилуулна.</p>	Барилгын ажлын гүйцэтгэлийн явц (хувь)	10	100	Улсын төсөв болон гадаадын зээл тусламж 65,104.0 сая төгрөг
	<p>2.2.Орон нутаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн Шүүх шинжилгээний хэлтсүүдэд стандартын шаардлага хангасан байртай болж, аймаг орон нутагт хийх шинжилгээний төрөл, зүйлийг нэмэгдүүлж, иргэд, хууль хяналтын байгууллагад үзүүлэх үйлчилгээг ойртуулна.</p>	Барилгын ажлын явц, гүйцэтгэл	3	12 (Өвөрхангай, Ховд, Дорноговь, Орхон, Сүхбаатар, Төв, Увс, Дундговь, Говь-Алтай, Завхан, Хэнтий, Сэлэнгэ)	Улсын төсөв, 45,200.0 сая төгрөг
	<p>2.3.Бүсийн шүүх шинжилгээний төвүүдийн хүчин чадлыг сайжруулж, авто техник, шүүх сэтгэц, хүрээлэн буй орчин, хими, биологи, бактериологи, шүүх эд эсийн зэрэг шинэ төрлийн шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж техник хэрэгслийг шийдвэрлэж, аймаг, орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй хүргэнэ.</p>	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Улсын төсөв 16,500.0 сая төгрөг
	<p>2.4.Самбалхүндэв дурсгал, хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэнгийн 1 га газарт шарил түр хадгалах зориулалттай барилга барих техник, эдийн засгийн үнэлгээг хийлгэж, холбогдох зөвшөөрлийг авна.</p>	Хэрэгжилтийн хувь	-	100	Улсын төсөв, 350.0 сая төгрөг
	<p>2.5.Шуурхай албаны болон цогцос зөөвөрлөх стандартын зориулалт бүхий тээврийн хэрэгслийн</p>	Автомашинны тоо	0	17	Улсын төсөв,

	хэвийн ажиллагааг хангах, тасралтгүй явуулах ажлын хүрээнд байгууллагын автомашины парк шинэчлэлийг бүрэн хийж тогтмолжуулна.					2,800.0 сая төгрөг
	2.6.Шүүх шинжилгээний байгууллагад шаардлагатай орон тоог нэмж батлуулна.	Нэмж батлуулсан орон тоо	741	990	-	-
	2.7."Монгол Улсын Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (Мон-22)"-ийн хүрээнд шинжээч эмч, мэргэжилтэн нарыг холбогдох сургалтад үе шаттайгаар хамруулж, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлж, чадавхжуулна.	Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо	0	52	Төслийн санхүүжилт	
	2.8.БНХАУ, Япон улсын ижил төрлийн байгууллагатай гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд, "Санамж бичиг" байгуулна.	Байгуулсан "Санамж бичиг"-ийн тоо	0	2	-	-
	2.9. Олон улсын ур чадварын сорилтын хөтөлбөр, лаборатори хоорондын үр дүнгийн харьцуулалтын шалгалтад Хими, ДНХ, Цахим технологийн шинжилгээний лабораторийг хамруулж, шинжилгээний үр дүнг баталгаажуулсан байна.	Лабораторийн тоо	1 (АНУ-ын "Collaborative Testing Services"-ын сорилтод хамрагдсан.)	3		Улсын төсөв 600.0 сая төгрөг
	2.10. Олон улсын стандартаар магадлан итгэмжлэгдсэн байгууллагын ур чадварын сорилтод шинжилгээний лабораторийн алба хаагчдыг хамруулж, баталгаажуулсан байна.	Хамрагдсан алба хаагчдын тоо	11 (БНСУ-ын "PT-2023-66, KOLAS" ур чадварын (дунд ангилал: 10.007) ур чадварын сорилтод хамрагдсан.)	100		Улсын төсөв 800.0 сая төгрөг
	2.11.Алба хаагчдыг мэргэжил, мэргэшлийн дагуу гадаад дотоодын урт, богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнд хамруулж, тэдний мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшнийг дээшлүүлнэ.	Хамрагдсан алба хаагчдын тоо	45	100		Улсын төсөв 800.0 сая төгрөг
ГУРАВ. ДЭВШИЛТЭД ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ НЭВТРҮҮЛНЭ.						
МЭРГЭШСЭН ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛНЭ.	3.1.Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг болон хүний оролцоог багасгах зорилгоор цаасны хэрэглээг 30-50% бууруулж, байгууллагын үйл ажиллагаанд ухаалаг хэрэглээг нэвтрүүлж, хэвшүүлэх	Хэрэгжилтийн хувь	100	100		Улсын төсөв 600.0 сая төгрөг
ДЭВШИЛТЭД ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ПРОГРАММ						

ХАНГАМЖИЙГ НЭВТРҮҮЛНЭ.	ажлын хүрээнд технологийн дэвшилд суурилсан цахим системийг нэвтрүүлнэ.				
3.2. Шүүх анагаах ухааны шинжилгээ хийлгэх, хонгио, хошуу бүртгүүлэх үйлчилгээг иргэд, байгууллагуудад цаг хугацаа алдалгүй, түргэн шуурхай хүргэх, талийгаачтай салах ёс гүйцэтгэх үйлчилгээг тогтоосон цагийн хуваарийн дагуу, чирэгдэлгүй үзүүлэх ажлын хүрээнд байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахимд шилжүүлнэ.	Цахимжуулсан үйлчилгээний тоо	1	3	Улсын төсөв 200.0 сая төгрөг	
3.3.Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн шүүх шинжилгээний хэлтэст галт зэвсгийн хонгио, хошуу автомат харьцуулалтын “Абес-Арсенал” систем салбар станцыг суурилуулна.	Суурилуулсан станцын тоо	0	2	Улсын төсөв 3,000.0 сая төгрөг	
3.4.ДНХ-ийн нэгдсэн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, тасралтгүй явуулахад шаардлагатай иж бүрэн техник, тоног төхөөрөмж, программ хангамж, урвалж, бодис, хэрэгслийг тогтмол шийдвэрлэнэ.	Хэрэгжилтийн хувь	100	100	Улсын төсөв 2,500.0 сая төгрөг	
3.5.Гарын мөр, галт зэвсгийн шинжилгээний адилтгал, мэдээллэйн нэгдсэн санд системийн шинэчлэлт хийнэ.	Шинэчлэлт хийгдсэн системийн тоо	0	2	Улсын төсөв 10,100.0 сая төгрөг	
3.6.Шүүх дүрс оношилгооны мэдээллэйн болон гуллын мөрийн төрөлжсөн санг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, санд баяжилт хийнэ.	Сангийн баяжилтын тоо	0	100	Улсын төсөв 710.0 сая төгрөг	
3.7. Олон улсын жишигт нийцсэн албан ёсны тусгай зориулалтын программыг ашиглан Инженер-техникийн шинжилгээг хийхэд шаардлагатай албан ёсны тусгай зориулалтын программ хангамжийн ашиглах эрхийн сунгалтыг тухай бүр хийнэ.	Программ хангамжийн тоо	3	5	Улсын төсөв 230.0 сая төгрөг	
3.8.Хүний гадна дүр төрхийн шинжилгээний чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа хийж, шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, 3D загварчлал дээр биометрик мэдээллийг боловсруулна.	Ажил, арга хэмжээний тоо	0	1	Улсын төсөв 506.2 сая төгрөг	
3.9.Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний лабораторийг шинээр байгуулна.	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Улсын төсөв	

	<p>3.10.Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний чиглэлээр лабораторийг шинээр байгуулна.</p> <p>3.11.Хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний лабораторид ус, хөрсний чанар, найрлага, бохирдол болон цацрагийн бохирдол зэрэгт Байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцож дүгнэлт гаргахад шаардлагатай зөөврийн болон лабораторийн тоног төхөөрөмж, программ хангамжийг шийдвэрлэнэ.</p> <p>3.12.Физикийн шинжилгээнд "Раман спектроскоп"-ийн багажийг нэвтрүүлж, 3000 гаруй бодисын мэдээллийн сантай шууд харьцуулалт хийж, үл мэдэгдэх дээжийг таних шинжилгээ хийнэ.</p> <p>3.13.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээний лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Хийн хроматографи масс спектрометр багаж (GC/MS)-ийг шийдвэрлэж, "TgNagc" маркийн зөөврийн багажийг худалдан авч, шинжилгээг өндөр нарийвчлалтай, түргэн шуурхай хийнэ.</p> <p>3.14.Хуурамч эмийг илрүүлж оношлох, эмийн бодис тодорхойлох шингэний хроматографи масс спектрометр багаж (LC/MS), "Rotary vacuum evaporator", "FTIR Spectrometer" тоног төхөөрөмж худалдан авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.</p> <p>3.15.Шүүх шинжилгээний байгууллагад хийгдэж буй шинжилгээний нэр төрөл, цар хүрээг өргөжүүлэх ажлын хүрээнд хорт бодис тодорхойлох "ABL800 FLEX blood gas analyzer, 190-1100 UV/VIS Spectrophotometer" шинжилгээний техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.</p> <p>3.16.Барилга, инженерийн байгууламжид үзлэг, шинжилгээ хийж, норм дүрэм, стандартын шаардлагад</p>	<p>Шинжилгээний тоо</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Шинжилгээний тоо</p>	<p>0</p> <p>247</p> <p>179</p> <p>1</p> <p>0</p> <p>0</p> <p>0</p>	<p>500</p> <p>350</p> <p>220</p> <p>2</p> <p>50</p> <p>100</p> <p>15</p>	<p>1,960.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 9,530.4 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 2,150.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 873.75 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 677.7 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 1,030.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 120.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв</p>
--	--	--	--	--	---

	<p>нийцэж буй эсэх шинжилгээг хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг шийдвэрлэнэ.</p> <p>3.17.Шүүх анагаах ухааны шинжилгээнд Компьютер томографын (КТГ) шинжилгээний аппаратыг нэвтрүүлж, хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг тогтоох шинжилгээг хийнэ.</p> <p>3.18.Шүүх эд эсийн шинжилгээнд тусгай будгуудыг нэвтрүүлж, нас барсан шалтгааныг нарийвчлан тогтоож, шинжилгээний үр дүнг сайжруулна.</p> <p>3.19.Хэргийн газрын үзлэгээр бэхжүүлсэн гэрэл зургийг "Fujifilm Frontier LP9700" төхөөрөмжөөр боловсруулж, өнгө дүрслэлийг сайжруулна.</p> <p>3.20."Foster freeman VSC 8000HS" төхөөрөмж ашиглан хуурамч болон засварласан бичиг баримтад нарийвчилсан шинжилгээ хийж, үйлдлийн дарааллыг тогтооно.</p> <p>3.21.Шүүх бактериологийн шинжилгээнд ашиглаж буй молекул биологийн аргын "Bio-rad CFX touch real time PCR, Bioneer Exiprep nuclease acid extraction system" аппаратуудын хэвийн ажиллагаанд шаардлагатай урвалж бодисоор тогтмол хангаж, бэлгийн замаар дамжих халдварын эх үүсвэрийг нарийвчлан тогтооно.</p>				<p>1,223.4 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 4,000,0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 60.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 600.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв, 150.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв 120.0 сая төгрөг</p>
<p>ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ БААЗЫГ БЭХЖҮҮЛНЭ.</p>	<p>ДӨРӨВ.ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ БААЗЫГ БЭХЖҮҮЛНЭ.</p> <p>4.1.ШУА, ДХИС болон дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран шинжилгээний чиглэлээр судалгааны ажил хийнэ.</p> <p>4.2.Алба хаагчдад эрүүл мэндийн тусламж, сэргээн засах үйлчилгээ үзүүлэхээс гадна тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, дадлага, сэтгэл засах, сувиллын зориулалт бүхий төвийг байгуулна.</p>	<p>Шинжилгээний тоо</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Боловсруулсан гэрэл зургийн тоо</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Шинжилгээний тоо</p> <p>Судалгааны ажлын тоо</p> <p>Ажлын гүйцэтгэлийн явц (хувь)</p>	<p>26337</p> <p>2990</p> <p>349701</p> <p>0</p> <p>1394</p> <p>0</p> <p>0</p>	<p>27000</p> <p>3800</p> <p>36000</p> <p>100</p> <p>1450</p> <p>3</p> <p>100</p>	<p>Улсын төсөв 100.0 сая төгрөг</p> <p>Улсын төсөв, 500.0 сая төгрөг</p>

ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН НЭР:

Хоёр. Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитраж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, нэгдсэн болон төрөлжсөн санд баяжилт хийх.

<p>ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН БҮРТГЭЛИЙГ ХӨТӨЛЖ, ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ОБЪЕКТЫН БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ ХАНГАНА.</p>	<p>1.1.Бүсийн шүүх шинжилгээний төв, аймгийн Шүүх шинжилгээний хэлтсээс илгээх бичгээр ирүүлсэн шинжилгээний дээжийг хүлээн авч, хариуг цахим хаягаар урьдчилан илгээнэ. 1.2.Нас барсан тухай гэрчилгээ, салах ёс гүйцэтгэх ажиллагааны үед баримтлах зааварчилгааг тухай бүр талийгаачийн ар гэрт өгч, салах ёс гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулна. 1.3.Шинжээч томилох эрх бүхий этгээдээс ирүүлсэн шийдвэрийг хүлээн авч, бүртгэн, гарсан шинжилгээний хариуг (шинжээчийн дүгнэлт) хуулийн хугацаанд хүргүүлнэ. 1.4.Шинжээчээс ирүүлсэн шинжилгээний хугацаа сунгуулах хүсэлтийг хүлээн авч, үндэслэлтэй эсэхийг хянаж, эрх бүхий этгээдэд хугацааг сунгасан тухай мэдэгдэнэ. 1.5.Үзлэг, шинжилгээний явцад харьцуулах шинжилгээнд загвар, дээж нэмж авах болон бусад асуудлыг эрх бүхий этгээдэд уламжлан шийдвэрлүүлнэ. 1.6.Яам, агентлаг болон бусад байгууллагуудад тухай бүр холбогдох статистик мэдээг хүргүүлнэ. 2.1.Шинжилгээ хийлгэх шийдвэрийг хүлээн авч шинжээч болон шинжээчдийн багт цахимаар хуваарилж, шинжилгээ хийж дууссаны дараа дүгнэлтийг эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгнө. 2.2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.</p>	<p>Албан бичгийн тоо</p> <p>Олгосон гэрчилгээний тоо</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Хэрэгжилтийн хувь</p> <p>Нийт шинжилгээний тоо</p> <p>Илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтын тоо</p>	<p>553</p> <p>2093</p> <p>100</p> <p>100</p> <p>100</p> <p>100</p> <p>64266</p>	<p>600</p> <p>2300</p> <p>100</p> <p>100</p> <p>100</p> <p>100</p> <p>68000</p>	<p>-</p> <p>-</p> <p>Улсын төсөв, 300.0 сая төгрөг</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>
<p>ҮЗЛЭГ, ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ НЭГ БҮРИЙН ЧАНАРТ ОНЦГОЙ АНХААРАХ, ХУУЛИЙН ХУГАЦААГ НАРИЙН БАРИМТЛАХ, ШИНЖЭЭЧИЙН БИЕ ДААСАН</p>		<p>Криминалистикийн шинжилгээний шинжээчид 52626, Инженер-техникийн шинжилгээний шинжээчид 20, байгалийн ухааны</p>	<p>Үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүр оролцож, ул мөр,</p>	<p>-</p>	

ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАНА.	2.3.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн байгалийн ухааны шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо	Химийн 7814, физикийн 179, биологийн 6360, ДНХ-ээр эцэг тогтоох 418, ДНХ-ийн бусад 1379, хүрээлэн буй орчны 247 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан.	шинжилгээний шинжээчид 2 ул мөр эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлсэн.	эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх ажиллагааг хийж гүйцэтгэнэ.	-
	2.4.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн инженер-техникийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо	Инженер-техникийн шинжилгээний чиглэлээр 852 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хургуулна.	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хургуулна.	-
	2.5.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн шүүх анагаах ухааны үзлэг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо	5231 цогцост задлан шинжилгээ, 14 эксгумац, 26337 хүнд гэмтлийн зэрэг тогтоох, 104 хүнд нас тогтоох, 2018 хүнд бэлгийн холбогдолтой үзлэг, шинжилгээ,	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хургуулна.	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хургуулна.	-

			бактериологийн 1394 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.	дүгнэлт гарган хүргүүлнэ.	
2.6. Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн шүүх сэтгэцийн шинжилгээ хийж, хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо	395	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хүргүүлнэ.		-
2.7. Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн хэргийн материалаар шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо	1398	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хүргүүлнэ.		-
2.8. Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн криминалистикийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.	Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо.	арын мөрийн 3486, галт зэвсгийн 632, тэсрэх төхөөрөмжийн 18, мөр судлалын 1349, материал судлалын 19, бичиг баримтын 1513, бусад 8 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.	Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хүргүүлнэ.		-

	<p>2.9.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн эдийн засгийн болон хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.</p>	<p>Шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тоо</p>	<p>111</p>	<p>Үндсэн чиг үүргийн хүрээнд эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх шийдвэрийг үндэслэн шинжилгээг хийж, дүгнэлт гарган хургуулна.</p>	<p>-</p>
	<p>2.10.Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийнэ.</p>	<p>Сангийн баяжилтын тоо</p>	<p>“Абес-Арсенал” системийг 3407 хонгио, 2840 хошуугаар, “Адис-Папиллон” системийг 6278 гарын мөр, 25403 гарын дардсаар, ДНХ-ийн мэдээллийн нэгдсэн санг 899 хүний генетик мэдээллээр тус тус баяжуулсан.</p>	<p>Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийсэн байна.</p>	<p>-</p>
	<p>2.11.Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн санд баяжилт хийнэ.</p>	<p>Сангийн баяжилтын тоо</p>	<p>Нэр, хаяг тодорхойгүй цогцосны мэдээллийн санд 1993-2020 онуудад 4390 цогцосны мэдээлэл бүртгэсэн.</p>	<p>Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн санд бүртгэж, баяжуулсан байна.</p>	<p>-</p>
	<p>2.12.Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцсыг оршуулна.</p>	<p>Ажил, арга хэмжээний тоо</p>	<p>Нийт 80 цогцос оршуулсан.</p>	<p>Засгийн газрын 2009 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан</p>	<p>-</p>

				<p>“Зарим цогцос оршуулах журам” болон Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ийн өдрийн “Журам батлах тухай” А/514 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p>	
--	--	--	--	--	--

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР